

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Гүйцэтгэлийн түвшин		
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1		2	3	4	5		6	7
Яамны стратегийн зорилт 5. Кибер аюулгүй байдлыг хангах, хэрэгжилтийг зохион байгуулах									
Зорилт 1. Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулна.		180 Улсын төсөв				I-IV			
1.	Арга хэмжээ 1.1. Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагад тавигдах шаардлагыг тодорхойлж, жагсаалтыг шинэчлэн боловсруулна.	20 Урсгал зардал	Засгийн газрын тогтоолын төслийн тоо	0	-	1	ЦХИХХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/105 дугаар тушаалаар Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, хурлыг зохион байгуулсан. Ажлын хэсгийн гишүүд хамтран кибер аюулгүй байдлын тухай хуульд нийцүүлэн онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагад тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлсон. Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтэд үр дагаврын үнэлгээ	2025.07-2025.12 сар	50%

							тайланд үндэслэн цаашид онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагыг байгууллагын нэр эсхүл үйл ажиллагааны чиглэлээр тодорхойлохыг шийдвэрлэхээр болсон.		
2.	Арга хэмжээ 1.2. Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх этгээдийг бүртгэх ажлыг зохион байгуулна.	-	Шалгалт хийсэн байгууллагын тоо Бүртгэж, зөвшөөрөл олгосон хуулийн этгээдийн тоо	0 34	34 37	34 37	Зөвшөөрөл бүхий 29 байгууллагад шалгалт хийх удирдамжийг Салбарын хяналтын газраас боловсруулсан. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/06 дугаар тушаалаар мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх хүсэлт ирүүлсэн хуулийн этгээдийн материалыг магадлан шалгах байнгын ажлын хэсгийг байгуулж, мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх эрхийг нийт 41 хуулийн этгээдэд олгосон.	2025.01-2025.12 сар	75%
3.	Арга хэмжээ 1.3. "Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам, аргачлал"-ын хэрэгжилтийг хангуулна.	-	Бүртгэж, зөвшөөрөл олгосон хуулийн этгээдийн тоо	4	10	10	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/06 дугаар тушаалаар кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх хүсэлт ирүүлсэн хуулийн этгээдийн материалыг магадлан шалгах байнгын ажлын хэсгийг байгуулсан. Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх эрх авах хүсэлтүүдийг магадлан шалгаж, нийт 26 байгууллагад эрх олгосон.	2025.01-2025.12 сар	100%

4.	Арга хэмжээ 1.4. Тоон гарын үсгийн гэрчилгээжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд шалгалт хийж, дүгнэлт гаргана.	-	Шалгалт хийсэн байгууллагын тоо	0	3	-	Тоон гарын үсгийн гэрчилгээ олгох үйл ажиллагаанд шалгалт хийх удирдамжийг боловсруулсан.	2025.01-2025.06 сар	30%
5.	Арга хэмжээ 1.5. Үндэсний хэмжээнд кибер аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагын тогтолцооны суурь судалгаа хийх, аюулгүй байдлыг шалгах зааварчилгаа боловсруулна.	20 Урсгал зардал	Судалгааны тоо Зааварчилгааны тоо	0 0	-	1 1	Кибер аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагын суурь судалгаа хийх санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр “Кибер аюулгүй байдлын хүний нөөцийг хөгжүүлэх төсөл”-ийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулсан. Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх системийн хөгжүүлэлтийг И-Монгол академи УТҮГ-аас хийж байна.	2025.07-2025.12 сар	Хэрэгжих хугацаа болоогүй.
6.	Арга хэмжээ 1.6. Кибер халдлага, зөрчил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх систем хөгжүүлэх тооцоо судалгаа хийнэ.	100 Улсын төсөв	Судалгааны тоо	0	-	1	Кибер халдлага, зөрчил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх систем хөгжүүлэх тооцоо судалгааг хийх ажлыг байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулж, ажлын даалгаврыг боловсруулан батлуулсан. Тендерийн шалгаруулалтыг зохион байгуулах үнэлгээний хороог байгуулах тушаалын төслийг боловсруулж, яамны зохион байгуулалтын нэгжийн дарга нараас санал авч байна.	2025.07-2025.12 сар	Хэрэгжих хугацаа болоогүй.
7.	Арга хэмжээ 1.7. Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт нөлөөллийн үнэлгээ хийлгэнэ.	40 Улсын төсөв	Үнэлгээний тоо	0	-	1	Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтэд үр дагаварт үнэлгээ хийх ажлын даалгаврыг боловсруулж, батлуулсан. Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/95 дугаар тушаалаар үнэлгээний хороог байгуулж, тендер шалгаруулалтыг зохион байгуулсан. Тендерт шалгарсан	2025.07-2025.12 сар	70%

							байгууллагатай ЦХИХХЯ/20250203053 дугаартай үйлчилгээний гэрээг байгуулж, кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт нөлөөллийн үнэлгээ хийлгэж ажлыг эхлүүлсэн.		
Зорилт 2. Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх бүтцийн үйл ажиллагааг сайжруулна.		-	Төслийн тоо Сургалтад хамруулсан албан хаагчийн тоо	0 15	1 30	I-IV			
8.	Арга хэмжээ 2.1. Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх Нийтийн төвийн төлөвшлийг үнэлэх арга хэмжээг зохион байгуулна.	-	Төслийн тоо	0	-	1	Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх Нийтийн төв УТҮГ-ын төлөвшлийг үнэлэх судалгааг Олон Улсын Цахилгаан холбооны байгууллагатай хамтран 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулахаар тохиролцож, бэлтгэл ажлыг хангаж байна.	2025.01- 2025.12 сар	Хэрэгжи х хугацаа болоогү й.
9.	Арга хэмжээ 2.2. Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төвийн албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулна.	-	Сургалтад хамруулсан албан хаагчийн тоо	15	22	30	Кибер аюулгүй байдлын хүний нөөцийг хөгжүүлэх төслийн хүрээнд Нийтийн төвийн 4 албан хаагчийг 2025 оны 02 дугаар сарын 7-8, 14-15, 22-ны өдрүүдэд зохион байгуулсан “Хортой кодын шинжилгээ хийх” сургалтад, 4 албан хаагчийг 2025 оны 1 сарын 06-наас 10-ны өдрүүдэд зохион байгуулсан “SOC”-ын сургалтад тус тус хамруулсан. Одоогоор нийт 23 албан хаагчийг сургалтад хамруулах ажлыг зохион байгуулсан.	2025.01- 2025.12 сар	100%

Зорилт 3. Кибер аюулгүй байдлын Зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.		-	Хэрэгжилтийн хувь	0	100	I-IV			
10.	Арга хэмжээ 3.1. Кибер аюулгүй байдлын зөвлөлийн төлөвлөгөө, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулна.	-	Хэрэгжилтийн хувь	0	100	I-IV	Кибер аюулгүй байдлын зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийг I улирлын байдлаар гаргаж, Ажлын албанд хүргүүлсэн. Зөвлөлийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	2025.01-2025.12 сар	100%
Зорилт 4. Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чадавхыг сайжруулж, мэдээлэл солилцоо, хамтын ажиллагааг уялдуулан зохицуулна.		231.25 Улсын төсөв	Арга хэмжээний тоо Зохион байгуулсан семинарын тоо Зөвлөмжийн тоо	- - -	1 1 1	I-IV			
11.	Арга хэмжээ 4.1. "Ази номхон далайн бүс нутгийн кибер дадлага, сургуулилт 2025" арга хэмжээг зохион байгуулна.	93.75 Улсын төсөв 82.5 Урсгал зардал	Арга хэмжээний тоо	0	1	III-IV	"Ази номхон далайн бүсийн кибер сургуулилт 2025" арга хэмжээг 2025 оны 09 сарын 02-06-ны өдрүүдэд зохион байгуулахаар Олон Улсын Цахилгаан холбооны байгууллагатай тохиролцсон. Хамтын ажиллагааны гэрээний төслийг Монгол хэлнээ орчуулж, Байгууллага хоорондын гэрээ байгуулах журмын 4.1-д заасны дагуу Гадаад харилцааны яамаар хянуулж, гэрээ байгуулах зөвшөөрлийг авсан. Арга хэмжээг зохион байгуулах ажлын даалгаврыг боловсруулж	2025.07-2025.12 сар	100%

							батлуулсан. Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/92 дугаар тушаалаар тендерийн шалгаруулалтыг зохион байгуулах үнэлгээний хороог байгуулж, ЦХИХХЯ/20250103054 тендерийг зарласан боловч компани оролцоогүй. ЦХИХХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/127 дугаар тушаалаар кибер сургуулилт зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн хурлаар бэлтгэл ажлын төлөвлөөг боловсруулсан. Мөн ОУЦХБ-тай хамтарсан төлөвлөгөөг боловсруулж, 14 хоног тутам цахимаар хуралдаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.		
13.	Арга хэмжээ 4.2. Монгол Улсын кибер аюулгүй байдлын өнөөгийн түвшинг үнэлэх судалгааны үр дүнг танилцуулж, гаргана.	35 Урсгал зардал	Зохион байгуулсан семинарын тоо, Зөвлөмжийн тоо	0 0	1 1	-	Монгол Улсын кибер аюулгүй байдлын өнөөгийн түвшинг үнэлэх судалгааг Оксфордын их сургуулийн Кибер аюулгүй байдлын чадавхын үнэлгээний төвтэй хамтран 2024 оны 08 дугаар сараас 2025 оны 02 дугаар сарын хооронд зохион байгуулсан. Судалгааны багаас ирүүлсэн тайлангийн төсөлд холбогдох байгууллагуудаас санал авахаар 2025 оны 01 сарын 08-09-ний өдрүүдэд хэлэлцүүлэг зохион байгуулж, ирүүлсэн саналыг нэгтгэн тайлангийн төсөлд тусгасан. Монгол Улсын кибер аюулгүй байдлын өнөөгийн түвшнийг үнэлэх судалгааны үр дүнг танилцуулах хурлыг 2025 оны 02 дугаар сарын	2025.01- 2025.06 сар	100%

							19-ний өдөр зохион байгуулсан. Хурлын бэлтгэл ажлын хүрээнд өмнө судалгаанд оролцсон төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын төлөөлөлд урилга хүргүүлж, олон нийтэд нээлттэй оролцох боломжийг бүрдүүлэх үүднээс шууд дамжуулалтыг зохион байгуулалтыг хангаж ажилласан. Мөн судалгааны тайлангийн Монгол хэл дээрх орчуулгын хувилбарыг гаргаж, Тагнуулын ерөнхий газарт 2025 оны 02/956 тоот албан бичгээр хүргүүлэн хянуулсан. Улмаар Монгол Улсын кибер аюулгүй байдлын өнөөгийн түвшин, дараагийн түвшинд хүргэхийн тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмжийг бүрэн эхээр нь байгууллагын цахим хуудсанд байршуулж, олон нийтэд ил тод хүргэсэн.		
14.	Арга хэмжээ 4.3. Кибер аюулгүй байдлыг хангахад хиймэл оюуныг ашиглах талаар дүгнэлт, зөвлөмж гаргана.	20 Улсын төсөв	Зохион байгуулсан семинарын тоо, Зөвлөмжийн тоо	0 0	1 1	-	2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр Монгол Улсын Гадаад харилцааны яаманд “Хиймэл оюуны хэрэглээ: Кибер аюулгүй байдлын бэлэн байдлын хэмжүүр” семинарыг Английн Оксфордын их сургуулийн баг, Японы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг ЖАЙКА-тай хамтран зохион байгуулсан. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагын нийт 100 гаруй мэргэжлийн судлаач, шинжээчдийг хамруулсан. Судалгааны тайлан, зөвлөмжийн төслийг 2025 оны 05 сарын 12-ны өдөр бэлэн болгосон.	2025.01- 2025.06 сар	100%

Зорилт 5. Нийтийн түлхүүрийн дэд бүтцийг хөгжүүлнэ.		8,160 Гадаадын зээл, тусламж	Батлагдсан шаардлагын тоо Төслийн тоо Төслийн тоо	0 0 0	1 1 1	I-IV			
15.	Арга хэмжээ 5.1. Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцэд тавигдах шаардлагын төслийг боловсруулж, батлуулна.	-	Батлагдсан шаардлагын тоо	0	1	-	Нийтийн түлхүүрийн дэд бүтцэд тавигдах шаардлагын төслийг боловсруулж, Тоон гарын үсгийн гэрчилгээ олгох тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудад танилцуулж санал авсан. ЦХИХХ-ны сайдын тушаалаар батлуулахаар тушаалын төслийг боловсруулсан.	2025.01- 2025.06 сар	70%
16.	Арга хэмжээ 5.2. Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчилнэ.	8,160 Гадаадын зээл, тусламж	Төслийн тоо	0	1	I-IV	Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчлэх ажлыг Дэлхийн банкны "Ухаалаг Засаг-2" төслийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр ажлын даалгавар болон тендерийн баримт бичгийг боловсруулж, төслийн нэгжид хүргүүлсэн. Тендер шалгаруулалт хүлээгдэж байна.	2025.01- 2025.12 сар	50%
17.	Арга хэмжээ 5.3. Тоон гарын үсгийг олон улсад ашиглах нөхцөлийг бүрдүүлэх төслийг эхлүүлнэ.	-	Төслийн тоо	0	1	III-IV	Дэд бүтцийг шинэчилсний дараа төслийг эхлүүлнэ. Тоон гарын үсгийн хэрэглээний өнөөгийн нөхцөл байдал, хэрэглээг нэмэгдүүлэх талаар танилцуулга боловсруулж, Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн ээлжит хуралдаанд танилцуулсан. Үүнтэй холбоотойгоор тоон гарын үсгийн хэрэглэгчийн программ хангамжуудыг нэгтгэх, хэрэглэхэд хялбар болгох, танилт нэвтрэлтийн системд тоон гарын үсэг ашиглах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах талаар холбогдох	2025.07- 2025.12 сар	Хэрэгжих хугацаа болоогүй.

							байгууллагуудад чиглэл хүргүүлсэн.		
Зорилт 6. Хүний хувийн мэдээллийг хамгаалах бодлогын хэрэгжилтийг зохицуулна.		-	Батлагдсан баримт бичгийн тоо Батлагдсан баримт бичгийн тоо	0 0	1 1	I-IV			
18.	Арга хэмжээ 6.1. Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үед мэдээллийн аюулгүй байдлыг хангах шаардлага, үнэлгээ хийх зааварчилгаа, хадгалах технологид тавигдах шаардлагын төслийг боловсруулж, батална.	-	Батлагдсан баримт бичгийн тоо	0	1	I-II	Танилт нэвтрэлтийн биометрик мэдээллийг ашиглах талаар олон улсын чиг хандлага, Ази, Номхон далайн бүс нутгийн хэмжээнд үйлчилж байгаа олон улсын гэрээ конвенц, хууль эрх зүйн орчныг судлах судалгааны ажлыг эхлүүлсэн. Мөн Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн өнөөгийн хэрэгжилт, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага байгаа эсэхэд холбогдох мэргэжлийн чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтран ажиллаж байна.	2025.01-2025.06 сар	30%
19.	Арга хэмжээ 6.2. Дуу, дүрсний, дуу дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулахад тавигдах шаардлагыг батална.	-	Батлагдсан баримт бичгийн тоо	0	1	II-III	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 27,7-д заасан Дуу, дүрсний, дуу дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулахад тавигдах шаардлагыг төслийг боловсруулж, хуульд заасны дагуу Хүний эрхийн комиссоос саналыг авч тусган ажиллаж байна	2025.01-2025.06 сар	70%
Зорилт 7. Кибер аюулгүй байдлын мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлнэ.		85 Улсын төсөв Гадаадын зээл тусламж	Сургалтад хамруулсан багшийн тоо Сургалтын тоо	0 0 0	24 5 1	II-IV			

			Арга хэмжээний тоо						
20.	Арга хэмжээ 7.1. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах багш нарыг чадавхжуулах сургалтад хамруулна.	50 Гадаадын зээл, тусламж	Сургалтад хамруулсан багшийн тоо	0	12	24	Кибер аюулгүй байдлын хүний нөөцийг хөгжүүлэх төслийн хүрээнд ШУТИС-ын 9, МУИС-ын 2 багшийг 2025 оны 2 дугаар сарын 7-8, 14-15, 22-ны өдрүүдэд зохион байгуулсан "Хортой кодын, шинжилгээ хийх" сургалтад, мөн ШУТИС-ын 10 багш, МУИС-ын 3 багшийг 2025 оны 1 сарын 06-наас 10-ны өдрүүдэд зохион байгуулсан "SOC"-ын сургалтад тус тус хамруулсан. Нийт 24 багшийг чадавхжуулах сургалтад хамруулсан байна.	2025.01- 2025.06 сар	100%
21.	Арга хэмжээ 7.2. Төрийн байгууллагын болон онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын албан хаагчдад "Кибер аюулгүй байдал"-ын чиглэлээр сургалт зохион байгуулна.	20 Улсын төсөв	Сургалтын тоо	0	2	5	Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын хүний нөөцийг чадавхжуулах зорилгоор 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр "Онц чухал мэдээллийн дэд бүтцийн кибер аюулгүй байдал" сэдэвт сургалт зохион байгуулсан. Сургалтаар кибер халдлага, зөрчлийн өнөөгийн байдал, мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгэхэд анхаарах асуудлуудын талаар танилцуулж, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, байгууллагын тасралтгүй ажиллагааны төлөвлөгөө боловсруулах сэдвийн хүрээнд дасгал ажил хийсэн. Энэхүү арга хэмжээнд нийт 83 байгууллагын 115 албан хаагчид оролцсон.	2025.01- 2025.06 сар	100%

							Төрийн байгууллагын удирдах түвшний албан хаагчдад кибер аюулгүй байдлын тухай хууль болон түүнийг даган гарсан журмуудыг талаар мэдээлэл өгөх, хүний хувийн мэдээллийг хамгаалах талаар танилцуулах сургалтыг 2025 оны 4 сарын 25-ны өдөр зохион байгуулсан.		
22.	Арга хэмжээ 7.3. Бүх нийтийн кибер аюулгүй байдлыг хангах мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх арга хэмжээ зохион байгуулна.	15 Улсын төсөв	Арга хэмжээний тоо	0	1	1	НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран 2025 оны 04 сарын 02-ны өдөр "Залуучуудын цахим аюулгүй байдал" сэдэвт залуучуудын цахим аюулгүй байдлыг нэмэгдүүлэхэд олон талын оролцоог нэмэгдүүлэх хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, сурагчид нийт 50 гаруй хүн хамрагдсан. Мөн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд "Өсвөр үеийнхний цахим аюулгүй байдал" сэдэвт сургалт арга хэмжээг 2025 оны 06 сарын 13-ны өдөр зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.	2025.01-2025.06 сар	100%
Зорилт 8. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.		-	Архивд хүлээлгэн өгсөн баримтын тоо	0 29	1 24	I-IV			

			Шийдвэрлэлтийн дундаж хоногийн тоо						
23.	Арга хэмжээ 8.1. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад заасан баримт бичгийг хугацаанд нь бүрэн архивлана.	-	Архивд хүлээлгэн өгсөн баримтын тоо	0	-	1	Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх эрх олгохтой холбоотой баримт бичгүүдийг тухай бүр архивлахад бэлтгэж байна.	2025.01-2025.06 сар	100%
24.	Арга хэмжээ 8.2. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, холбогдох журамд заасны дагуу цохогдсон өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэнэ.	-	Шийдвэрлэлтийн дундаж хоногийн тоо	29	24	24	Тус газарт тайлант хугацаанд 1 өргөдөл ирснийг холбогдох талуудаас тайлбар авч, зохих журмаар шийдвэрлэсэн.	2025.01-2025.12 сар	100%
Зорилт 9. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлнэ		-	Төгсөгчдийн тоо	1 0 0	6 2 1	I-IV			
25.	Арга хэмжээ 9.1. Худалдан авах ажиллагааны сургалтад сурч, төгссөн байна.	-	Төгсөгчдийн тоо	1	3	6	Худалдан авах ажиллагааны сургалтад 2 албан хаагч хамрагдаж, 1 албан хаагч шалгалтад тэнцэж, гэрчилгээ авсан.	2025.01-2025.12 сар	75%
26.	Арга хэмжээ 9.2. Төрийн албаны сургууль Удирдлагын академийн богино болон дунд	-	Төгсөгчдийн тоо	-	-	2	Удирдлагын академийн мэргэшүүлэх сургалтад 2 албан хаагчийг сургахаар нэр хүргүүлсэн. Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1 албан хаагч	2025.01-2025.12 сар	100%

	хугацааны сургалтын хөтөлбөрт хамрагдана.						хамрагдаж байна. Ёс зүйн хороо болон Удирдлагын академиас хамтран зохион байгуулсан Ёс зүйн сургагч багш бэлтгэх сургалтад 1 албан хаагч хамрагдаж, төгссөн.		
27.	Арга хэмжээ 9.3. Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдана.	-	Төгсөгчдийн тоо	0	1	I-II	Сургалтад хамрагдаж байна.	2025.01- 2025.06 сар	50%